



МОНГОЛ УЛС  
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ  
ТОГТООЛ

2013 оны 03 сарын 27 өдөр

Дугаар 102

Улаанбаатар хот

Г Хорооны 2009 оны 275 дугаар Т  
тогтоолоор батлагдсан журамд  
нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3 дахь заалт, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ НЬ:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2009 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 275 дугаар тогтоолоор батлагдсан “Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга, маягтыг тогтоох журам”-ын 2 дугаар зүйлд дор дурьдсан агуулгатай 2.10 дахь заалтыг нэмсүгэй:

1/ “2.10. Даатгалын төлөөлөгчийн үйл ажиллагааны орлого нь 20.0 сая төгрөг ба түүнээс дээш хэмжээтэй бол даатгалын төлөөлөгч өөрийн орлогын тайлангаа энэ журмын 32 дугаар хавсралтаар төлөөлж буй компанидаа гаргаж өгөх бөгөөд тус компани нь төлөөлөгчдийн энэхүү тайланг нэгтгэн мөн журмын 1.2-т заасан хугацаанд Хороонд ирүүлнэ.

2. Журамд нэмэлтийг оруулж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х. Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.


ДАРГА-2

Д.БАЯРСАЙХАН



000243

Санхүүгийн зохицуулах хорооны  
2013 оны 3 дугаар сарын 27-ны өдөр  
... дугаар тогтоолын ... дүгээр хавсралт



“Даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн  
санхүүгийн нэмэлт тайлангийн агуулга,  
маягтыг тогтоох журам”-ын 32 дугаар хавсралт

/мянган төгрөгөөр/

Огноо	Даатгалын гэрээ хийсэн байгууллага	Даатгалын гэрээний үнэлгээ	Даатгалын хураамжийн орлого	Даатгалын төлөөлөгчийн шимтгэлийн дүн	ХАОАТ -ын дүн	Олговол зохих шимтгэлийн дүн
	...					
	...					
	...					
	Нийт дүн					

Тайланг гаргасан,

“.....” ХХК-ийн даатгалын төлөөлөгч.....овогтой.....

Баталгаажуулсан,

“.....” ХХК-ийн захирал.....

---00000---